

## ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

### 1.Гэрээ байгуулагчТалууд:

#### 1.1.Нэг талаас: Төсвийн шууд захирагч

**Мэдээллийн технологи, шуудан харилцаа  
холбооны газрын дарга**

(албан тушаал, нэр)

**Цагаан-Өвгөн Жадамбаа**

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

#### 1.2.Нөгөө талаас: Менежер

**Мэдээллийн технологийн үндэсний  
паркийн ерөнхий захирал**

(албан тушаал)

**Бавуужав Мягмарнاران**

(эцэг /эх/-ийн нэр, нэр)

бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар 31-ний өдрийг дуустал хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

### 2.Гэрээний агуулга, зорилго

2.1. " Мэдээллийн технологийн үндэсний паркийн 2015 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө нь " нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд Менежерээс хэрэгжүүлэх нийт болон тусгай ажил, үйлчилгээнүүд, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-үүд болон бусад эрх үүргийг тусгав.

2.2.Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах талаар менежерийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

### НЭГ.ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

#### 1. Менежерийн хүлээх үүрэг

#### 1.1.БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.1.1.Энэхүү гэрээний хавсралт болох "Мэдээллийн технологийн үндэсний паркийн 2014 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан **12 нийт ажил, үйлчилгээ** (энэхүү загварын 1.2-т дурдсан тусгай ажил, үйлчилгээ орохгүй)-г гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) бүрээр хэрэгжүүлнэ.

1.1.2.Энэхүү гэрээний хавсралт болох "Мэдээллийн технологийн үндэсний паркийн 2014 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан ажил, үйлчилгээнээс төсвийн шууд захирагчийн тусгайлан сонгосон, дор дурдсан (4.1, 4.2, 5.1, 5.2, 7.1) **5 тусгай ажил, үйлчилгээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

<i>Тусгай ажил, үйлчилгээ, тэдгээрийн зорилт (шалгуур үзүүлэлт)</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (чиглэл)</i>	<i>Хуанлын хугацаа, хүн/өдөр</i>
1	2	3
4.1 Инкубаторын сонгон шалгаруулалт, үнэлгээ, дүгнэлт хийх	а) Элсэгчдэд зориулсан семинар зохион байгуулах, элсэлт зохион байгуулах, байрлуулах, гэрээ байгуулах б) Сар тутмын үнэлгээ зохион байгуулах, шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх, дүгнэх в) Хагас жилийн үйл ажиллагаанд хууль эрх зүй, бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх д) Инкубаторын нэмэлт шинэ үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг судлах, төсөл хөтөлбөр гүйцэтгэх е) Зорилтот салбарын үйл ажиллагаанд шинжилгээ хийх, тэр чиглэлээр гарааны компаниудыг дэмжих, хамтран ажиллах	Жилдээ
4.2 Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх	а) Компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад дэмжих, сурталчлах ажлыг зохион байгуулах б) Удирдлага болон мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, семинар зохион байгуулах в) Инкубаторын багц үйлчилгээг үзүүлэх, үр дүнг мэдээлэх, танилцуулах д) Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх боломжийг судлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хянах, холбогдох дүрэм, журмыг нэвтрүүлэх, үр дүнг тайлагнах, сурталчлах	Жилдээ
5.1 МТИШ-ийг зохион байгуулах, хөгжүүлэх	а) МТИШ-ыг зохион байгуулах, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт гаргах, хамтын ажиллагааг сайжруулах	Жилдээ

	b) АБЗ-ийг ажиллуулах, хурлыг зохион байгуулах	
5.2 Ур чадвар дээшлүүлэх, стандарт нэвтрүүлэх	<p>a) Ментор, шинжээчдийн мэдээллийн сан бүрдүүлэх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах</p> <p>b) Мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоодын туршлагаас суралцах, нэвтрүүлэх</p> <p>c) МТ-ийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, семинарыг зохион байгуулах</p>	Жилдээ
7.1 Гарааны бизнесийг дэмжих бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	<p>a) Гарааны бизнесийг дэмжих, хурдасгуур хөтөлбөр хөгжүүлэх арга замыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх</p> <p>b) Шинэ гарааны компанийг сонгож, дэмжлэг үзүүлэх хурдасгуурт бэлтгэх хөтөлбөрийг ТББ-тай хамтран хэрэгжүүлэх, (Pre accelerator program – Startup Next)</p>	Жилдээ

## 1.2. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.2.1. "Нэгжийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан **1 дотоод ажил, үйлчилгээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) бүрээр хэрэгжүүлнэ.

### 1.3.МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ

1.3.1.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

Хүснэгт 2

<b>Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дэвшүүлсэн зорилт</b> (шалгуур үзүүлэлт)	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга зам</b> (өөрийгөө хөгжүүлэх чиглэл )	<b>Хуанлын хугацаа, хүн/өдөр</b>
1	2	3
<b>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-1:</b> <i>Гадаадын мэдээлэл технологийн хөгжлийн шилдэг арга туршлагыг нэвтрүүлэх боломжийг судлах</i>  (шалгуур үзүүлэлт)	а) Дэлхийн шилдэг мэдээлэл технологийн хөгжлийн чиг хандлагыг судалж нэвтрүүлэх б) Удирдлагын шилдэг арга барилыг эзэмших, туршлага судлах г) Олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалтанд оролцох боломжуудыг нээх в) Олон улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран туршлага солилцох	Жилдээ
<b>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -2:</b> <i>Байгууллагын ажилчдын багаар ажиллах, манлайлах ур чадварыг дээшлүүнэ.</i> (шалгуур үзүүлэлт)	а) Байгууллагын ажиллагсдын ажил хэргийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч, зөвлөгөө тусалцаа үзүүлсэн байх б) Байгууллагын газар, хэлтсийн ажлын уялдаа холбоог сайжруулж оновчтой менежментээр ханган, удирдлагын тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлнэ.	Жилдээ

1.4.Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг чанд мөрдөж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажиллана.

1.5.Гэрээний биелэлтийг төсвийн шууд захирагчид улирал тутам мэдээлж, хагас, бүтэн жилээр тайлагнана.

## 2. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

2.1.Менежертэй байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ (нийт болон тусгай ажил, үйлчилгээ)-нүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хамтран тодорхойлно.

2.2.Менежерийн мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хамтран тодорхойлно.

2.3.Менежерийн гэрээнд тусгагдсан нийт болон тусгай ажил, үйлчилгээ, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь түүнд байнгын дэмжлэг тусалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

## ХОЁР.БУСАД ЗҮЙЛ

### 3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана.

### 4. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.1.Гэрээг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулав. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

4.2.Менежер гэрээний биелэлтийг 2016 оны 01 дүгээр сарын 15-ны дотор багтаан тайлагнаж, төсвийн шууд захирагч 2016 оны 02 дугаар сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

### 5. Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1.Менежер гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн шууд захирагч холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.


5.2.Менежер гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн шууд захирагч түүнд туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### 6. Гэрээ байгуулсан:

#### Төсвийн шууд захирагч

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа  
холбооны газрын дарга  
(албан тушаал)

Тэмдэг

  
(гарын үсэг) /Ц.Жадамбаа/

(огноо)

#### Менежер

Мэдээллийн технологийн үндэсний  
паркийн ерөнхий захирал  
(албан тушаал)

Тэмдэг

  
(гарын үсэг) /Б.Мягмарнран/

(огноо)

..... о О о .....